Оюутнуудын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг сурах идэвх оролцоотой харьцуулж судалсан нь

Б.Энхзаяа[1], Т.Энхсайхан[1], Ц.Дэлгэрмаа[3], Д.Долгорсүрэн[3], Т.Энхнаран[4], У.Цэрэндолгор[5], Xihua Zeng[1], Т.Ганцэцэг[4,6]

[1]БНХАУ, Өмнөдийн Анагаах Ухааны Их Сургууль, Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
[2]Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
[3]АШУҮИС, Дорноговь АУС
[4]Шинжлэх ухааны академийн харьяа Тархи-Сэтгэл судлалын хүрээлэн
[5]Этүгэн их сургууль, Анагаахын сургууль
[6]АШУҮИС, Анагаах Ухааны Сургууль, Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхим
Цахим шуудан: enkhzaya.ba@gmail.com , Утас: 88008835

Түлхүүр үг:

Ковид-19
Оюутнууд
Агшингийн судалгаа
IUS-12
UWES-17

Товч утга:

Үндэслэл: Ковид-19 өвчний улмаас үүссэн хөл хорио нь оюутан, сурагчдын сурч боловсрох, нийгмийн харилцаанд ороход тодорхойгүй нөхцөл байдлууд үүсгэх, сурах идэвхи буурах зэргээр сөрөг нөлөө үзүүлж байна. **Зорилго:** Оюутнуудын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадвар ба сурах идэвх оролцоог судлах. **Зорилт:** Судалгаанд оролцогчдын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадвар ба сурах идэвх оролцооны түвшинг олон улсад ашиглагддаг асуумжуудаар үнэлж тодорхойлох. **Арга, аргачлал:** Их сургуулиудад суурилж агшингийн загвараар мэдээллээ Google forms платформийг ашиглан онлайнаар цуглуулсан. Тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг IUS-12, сурах идэвх оролцоог UWES-17 гэсэн стандарт асуумжуудыг ашиглав. Статистик боловсруулалтыг SPSS 24 программыг ашиглан хийсэн.
Үр дүн: Судалгаанд 17-29 насны нийт 697 оюутан хамрагдсаны дундаж нас нь 21.03±1.85 жил байв. Судалгаанд хамрагдсан оюутнуудын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадвар сул буюу асуумжийн нийт онооны дундаж нь 38.65±8.48 байсан ба үнэлгээний дэд бүлгээр авч үзвэл оюутнууд өнгөрсөнд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлаас (15.87±4.03)-ээс илүүтэй ирээдүйд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдалд (22.78±4.96) илүү тэвчээргүй хандаж байв. Түүнчлэн нийт оюутнуудын дийлэнх хувь нь сурах эрч хүч (дундаж 47.1%, сул 34.3%), сурах үйл явцдаа өөрийгөө зориулах чадвар (дундаж 62.7%, сул 26.3%), хичээлдээ уусан орох чадвар (дундаж 58.5%, сул 23.8%) зэрэг чадварууд дундаж ба сул түвшинд байсан. **Дүгнэлт:** Манай улсын оюутнууд нь тодорхойгүй нөхцөл байдлыг тэвчих чадвар сул бөгөөд сурах идэвх оролцоо нь хангалтгүй түвшинд байна.

Үндэслэл: Бидний өдөр тутмын амьдралд тодорхойгүй нөхцөл байдал таамаглах аргагүйгээр өрнөж байдаг ба энэхүү тодорхойгүй нөхцөл байдал нь ихэвчлэн тааламжгүй мэдрэмжийг үүсгэж байдаг. Тухайн тодорхойгүй нөхцөл байдлыг тэвчих, даван туулах чадвар нь хүн бүрт харилцан адилгүй янз бүр байдаг. Тухайлбал: зарим хүмүүс тодорхойгүй нөхцөл байдалд тэвчээртэй хандаж чаддаг байхад зарим нь сөрөгөөр хүлээн авч, түгших мэдрэмж ихэссэнээр тухайн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчин сөрөг мэдрэмжүүдийг өөртөө үүсгэдэг байна. Тодорхойгүй нөхцөл байдлыг тэвчиж чаддаггүй хүмүүс тухайн тодорхойгүй мэдээллийг өөрийг нь заналхийлж байна гэж сөргөөр хүлээж авдаг учраас өөрийн бие сэтгэцийг стресст өртүүлдэг[1,2].

Харин тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих гэдэг нь танин мэдэхүйн сөрөг туйлшрал бөгөөд энэ нь аливаа хүн өдөр тутмын амьдралд тохиолдох

тодорхойгүй нөхцөл байдлын талаар өөрийн танин мэдэхүй, сэтгэл хөдлөл, зан үйлийн талаас өгч буй хариу урвалаа хэрхэн хүлээн авч, хэрхэн ойлгож тайлбарлах, ямар хариу үйлдэл үзүүлэхэд нөлөөлдөг танин мэдэхүйн илрэл юм[3,4]. Тодорхойгүй нөхцөл байдлыг тэвчиж чаддаггүй хүмүүст тодорхойгүй нөхцөл байдалд орох нь тэвчишгүй хэцүү зүйл болдог тул тэд тодорхойгүй нөхцөл байдлаас, тодорхойгүй үйл явдлаас урьдчилан сэргийлэх эсвэл тодорхойгүй нөхцөл байдлыг үгүй болгохыг зорьж хамаг чадлаараа хяналт үүсгэхийг хичээдэг[5]. Үүний үр дүнд хэт их хичээх тусам асуудлыг буруу аргаар буюу оновч үгүйгээр даван туулах хандлагатай болсноос үр дүнд нь илүү их сэтгэл гутрал, сэтгэл түгшилтэд өртдөг.

Олон судалгаанууд тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих нь түгээмэл сэтгэл түгших эмгэг, улигт албадмал байдал, сандрах дайрлага, нийгмийн айдас, сэтгэл гутрах эмгэгийг үүсгэх үндсэн шалгаан болдог гэж баталсаар байна[6,3,7,8]. Өөрөөр хэлбэл энэхүү сөрөг туйлшралаас үүдээд хүмүүс асуудлыг эерэгээр шийдэх хандлага нь багасаж тодорхойгүй нөхцөл байдлаас зугтах, хяналтаа алдсан мэт мэдрэмж төрөх нь ихэсдэг[9,10] тул тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих нь эрүүл мэндийн талаас сөрөг үр дагавар үүсгэх нэг шалтгаан болдог гэж судлаачид үзэж байна[11,12]. Гэтэл сүүлийн жилдэд дэлхий дахинаа тархаад байгаа үхэлд хүргэх аюултай Ковид-19 халдварт өвчний улмаас үүссэн хөл хорионы нөхцөл байдлын нь оюутан, сурагчдын сурч боловсрох, нийгмийн харилцаанд орох эрх удаан хугацаанд хязгаарлагдснаас болж тэдний өмнө сурч боловсрохтой холбоотой тодорхойгүй нөхцөл байдлууд тулгархаас гадна сурах идэвх оролцоонд сөргөөр нөлөөлж байгааг судлаачид батлаж байна. Иймд бидний өмнө их дээд сургуульд сурч буй оюутнуудын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадвар болон сурах идэвх оролцоо зэргийг судлах хэрэгцээ тулгарч байна.

Зорилго: Бид энэхүү судалгаагаар оюутнуудын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг сурах идэвх оролцоотой харьцуулж судлахаар зорилоо.

Зорилт: Судалгаанд оролцогчдын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадвар ба сурах идэвх оролцооны түвшинг олон улсад ашиглагддаг асуумжуудаар үнэлж тодорхойлох.

Арга, аргачлал: Уг судалгааг анагаахын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг улсын болон хувийн их дээд сургуулиудад суурилж 2021 оны 12 сарын 05-аас 2022 оны 02 сарын 05-ны өдөр хүртэл ижил цаг хугацаанд агшингийн судалгааны загварыг ашиглаж, оюутан, залуусаас асуумж судалгааны аргаа Google forms платформ ашиглан онлайн хэлбэрээр мэдээ мэдээллээ цуглуулсан. Бид судалгаандаа тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг Intolerance of Uncertainty scale (IUS-12) 13, сурах идэвх оролцоог Utrecht Work Engagement Scale (UWES-S) 14 олон улсад түгээмэл хэрэглэдэг стандарт асуумжуудыг ашиглаж үнэлсэн. Судалгааны статистик боловсруулалтыг SPSS-24 программыг ашиглан тойм үзүүлэлтийн аргаар тоон утга ба эзлэх хувь, дундаж, стандарт хазайлтыг, Independent-Samples T-test-ийн аргаар стандарт асуумжуудын дунджийн ялгааг, Кронбахын альфа коэффициентоор стандарт асуумжийн хүчин төгөлдөр болон найдвартай байдлыг тус тус тодорхойлсон. Хамаарлыг Pearson Correlation анализын аргаар үнэлсэн. Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Ёс Зүйн Хорооны 2021/3-06 дугаартай ёс зүйн зөвшөөрлийн дагуу судалгааг хийсэн.

Үр дүн: Бидний судалгаанд анагаахын чилгэлээр их дээд сургуульд сурдаг 17-29 насны нийт 697 оюутан хамрагдсаны дундаж нас нь 21.03±1.85 жил байв.

Хүснэгт 1. Оюутнуудын хүн ам зүйн ерөнхий үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд		Тоо (n=697)	Хувь (100%)
1	Хүйс	Эрэгтэй	193	27.7
		Эмэгтэй	504	72.3
2	Насны бүлэг	<19 нас	159	22.8
		20-24 нас	515	73.9
		>25 нас	23	3.3
3	Үндсэн хаяг	Хот	332	47.6
		Хөдөө	365	52.4
4	Сурч буй дамжаа	1 дүгээр дамжаа	42	6.0
		2 дугаар дамжаа	189	27.1
		3 дугаар дамжаа	73	10.5
		4 дүгээр дамжаа	141	20.2
		5 дугаар дамжаа	169	24.2
		6 дугаар дамжаа	60	8.6
		Магистрын сургалт	23	3.3
5	Сурч буй мэргэжил	Ерөнхий эмчилгээ	381	54.7
		Шүд зэрэг бусад эмч	224	32.1
		Эмчээс бусад мэргэжил	92	13.2
6	Шашны итгэл үнэмшил	Шашин шүтдэг	365	52.4
		Шашин шүтдэггүй	332	47.6

Хүснэгт 1-ээс харахад бидний судалгаанд 193 (27.7%) нь эрэгтэй, 504 (72.3%) нь эмэгтэй оюутан хамрагдсаны 73.9% (n=515) нь 20-24 насныхан эзэлж байсан бол 332 (47.6%) нь Улаанбаатар хотын, 365 (52.4%) нь хөдөө орон нутгийн харъяалалтай байлаа. Сурч буй мэргэжлийг нь судлаж үзэхэд 54.7% (n=381) нь ерөнхий эмчилгээний (хүний их эмчийн), 32.1% (n=224) нь шүд, уламжлалт зэрэг бусад эмчийн, 13.2% (n=92) нь сувилагч, нийгмийн эрүүл мэнд зэрэг бусад мэргэжлээр тус тус суралцаж байв.

Хүснэгт 2. Оюутнуудын стандарт асуумжуудын найдвартай байдлыг үнэлсэн үр дүн

Асуулт	IUS-12 асуумж			Асуулт	UWES-S асуумж		
	Mean	Std. Deviation	Cronbach's Alpha if Item Deleted		Mean	Std. Deviation	Cronbach's Alpha if Item Deleted
IUS_1	3.45	1.107	0.839	UWES-1	3.38	1.340	0.911
IUS_2	3.49	1.086	0.838	UWES-2	3.34	1.207	0.910
IUS_3	3.47	1.131	0.835	UWES-3	4.00	1.370	0.912
IUS_4	2.91	1.082	0.851	UWES-4	3.42	1.394	0.913
IUS_5	3.51	1.144	0.839	UWES-5	2.92	1.293	0.912
IUS_6	3.20	1.118	**0.834**	UWES-6	3.33	1.268	0.908
IUS_7	3.54	1.159	0.844	UWES-7	3.29	1.345	**0.926**
IUS_8	3.62	1.196	0.852	UWES-8	3.66	1.286	0.908
IUS_9	2.50	1.234	0.856	UWES-9	4.12	1.348	0.908
IUS_10	2.82	1.148	0.844	UWES-10	3.16	1.428	0.912
IUS_11	3.31	1.107	0.850	UWES-11	4.01	1.434	0.910
IUS_12	2.84	1.127	0.849	UWES-12	2.96	1.369	0.912
				UWES-13	3.72	1.454	0.912
				UWES-14	3.31	1.218	0.910
				UWES-15	2.63	1.325	0.915
				UWES-16	3.44	1.311	0.908
				UWES-17	3.40	1.364	0.910

Судалгаанд ашигласан стандарт асуумжуудын найдвартай байлыг судлахад оюутнуудын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг үнэлэх (IUS-12) асуумжийн нийт Cronbach's Alpha коэффецент нь 0.856, сурах идэвх оролцоог үнэлэх (UWES-S) асуумжийн нийт Cronbach's Alpha коэффецент нь 0.916 байлаа. Мөн стандарт асуумж тус бүрийн асуултуудын Cronbach's Alpha коэффецент 0.834-0.926 хооронд хэлбэлзэж байгаа нь уг хоёр асуумжийн үр дүнг цаашид эрдэм шинжилгээний илтгэл өгүүлэлд ашиглах бүрэн боломжтой болохыг харууллаа (Хүснэгт 2).


Хүснэгт 3. Оюутнуудын стандарт асуумжуудад хариулсан онооны дунджийг хүйстэй харьцуулсан дүн

Асуумжуудын ангилал	Нийт (Mean±SD)	Хүйс		P утга
		Эрэгтэй (Mean±SD	Эмэгтэй Mean±SD)	
Тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг үнэлэх асуумж- (IUS-12)				
Өнгөрсөнд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчилт	15.87±4.03	15.49±4.04	16.01±4.03	0.927
Ирээдүйд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчилт	22.78±4.96	22.44±5.52	22.91±4.73	0.009
Сурах идэвх оролцоог үнэлэх асуумж - (UWES-S)				
Суралцах эрч хүч	3.39±0.98	3.32±1.07	3.42±0.95	0.070
Өөрийгөө зориулах чадвар	3.65±0.93	3.62±1.05	3.65±0.88	0.002
Хичээлдээ уусч орох чадвар	3.24±1.01	3.15±1.06	3.27±0.98	0.147

Тайлбар: **Independent-Samples T-test*

Оюутнуудын тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг үнэлэх (IUS-12) асуумжийн нийт онооны дундаж нь 38.65±8.48 байсан нь тодорхойгүй нөхцөл байдлыг үл хүлцдэг буюу тэвчих чадвар сул байгааг харуулж байна. Харин үнэлгээний дэд бүлгээр авч үзвэл оюутнууд өнгөрсөнд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлаас (15.87±4.03)-ээс илүүтэй ирээдүйд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдалд (22.78±4.96) илүү тэвчээргүй ханддаг нь ажиглагдаж байна. Мөн эрэгтэй оюутнуудтай (22.44±5.52) харьцуулбал эмэгтэй оюутнууд (22.91±4.73) ирээдүйд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг илүү их үл тэвчих хандлагатай нь статистикаар ($p<0.009$) батлагдсан. Нийт оюутнуудын сурах идэвхийг UWES-S асуумжаар судлахад уг асуумжийн нийт онооны дундаж нь (3.42±0.87) байсан ба энэ нь оюутнуудын сурах идэвх оролцоо дунд зэрэг байгааг харуулж байна. Суралцах эрч хүчийн дундаж (3.39±0.98) хичээлдээ уусч орох

чадварын дундаж 3.24±1.01 байлаа. Харин сурах үйл явцдаа өөрийгөө зориулах чадварын хувьд эмэгтэй оюутнууд (3.65±0.88) эрэгтэй оюутнуудаас (3.62±1.05) илүү байгаа нь статистик ($p<0.002$) ач холбогдол бүхий ялгаатай байв (Хүснэгт 3).



Зураг 1. Оюутнуудын сурах идэвхийг UWES-S асуумжаар үнэлсэн байдал

Зураг 1-ээс харахад оюутнуудын дийлэнх хувь нь сурах эрч хүч (47.1%), сурах үйл явцдаа өөрийгөө зориулах чадвар (62.7%), хичээлдээ уусан орох чадвар (58.5%) нь бүгд дундаж түвшинд байсан бол сурах эрч хүчийн 34.3%, сурах үйл явцдаа өөрийгөө зориулах чадварын 26.3% нь, хичээлдээ уусан орох чадварын 23.8% нь тус тус сул түвшинд байлаа. Харин оюутнуудын ердөө 7.2% нь сурах эрч хүч өндөртэй, 8.0% нь сурах үйл явцдаа өөрийгөө зориулах чадвар өндөртэй, 11.0% нь хичээлдээ уусан орох чадвар өндөртэй байлаа.

Хүснэгт 4. Стандарт асуумжуудын хоорондын хамаарлыг корреляцын аргаар үнэлсэн нь

Үзүүлэлт			Тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг үнэлэх асуумж (IUS-12)			Сурах идэвх оролцоог үнэлэх асуумж (UWES-17)		
			IUS-12 Нийт оноо	Ирээдүйд чиглэсэн үл тэвчилт	Өнгөрсөнд чиглэсэн үл тэвчилт	UWES-17 нийт оноо	Суралцах эрч хүч	Өөрийгөө зориулах чадвар
IUS-12 асуумж	Ирээдүйд чиглэсэн үл тэвчилт	Pearson Correlation	.954**					
		P утга	0.000					
		N	697					
	Өнгөрсөнд чиглэсэн үл тэвчилт	Pearson Correlation	.929**	.775**				
		P утга	0.000	0.000				
		N	697	697				
UWES-S асуумж	**UWES-S**	Pearson Correlation	0.009	0.061	-0.056			
		P утга	0.806	0.107	0.143			
		N	697	697	697			
	Суралцах эрч хүч	Pearson Correlation	-0.022	0.023	-.075*	.902**		
		P утга	0.558	0.546	0.048	0.000		
		N	697	697	697	697		
	Өөрийгөө зориулах чадвар	Pearson Correlation	0.012	0.064	-0.055	.903**	.747**	
		P утга	0.761	0.089	0.146	0.000	0.000	
		N	697	697	697	697	697	
	Хичээлдээ уусч орох чадвар	Pearson Correlation	0.035	.077*	-0.020	.885**	.677**	.692**
		P утга	0.352	0.042	0.590	0.000	0.000	0.000
		N	697	697	697	697	697	697

Тайлбар: ***. Correlation is significant at the 0.01 level (2-tailed), *. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).*

Бид тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг үнэлэх асуумж (IUS-12) ба сурах идэвх оролцоог үнэлэх асуумж (UWES-S)-ийн хоорондын хамаралыг Pearson Correlation аргаар судлаж үзэхэд тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадварыг үнэлэх асуумж (IUS-12)-ийн нийт оноо нь сурах идэвх

оролцоог үнэлэх асуумж (UWES-S)-ийн нийт оноотой хоорондоо ямар нэгэн хамааралгүй байлаа. Харин стандарт асуумжуудын дэд бүлгүүд нь хоорондоо хамааралтай байлаа. Тухайлбал суралцах эрч хүч нь өнгөрсөнд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчилттэй (-.075*, p<0.048) урвуу сул хамааралтай байна. Өөрөөр хэлбэл өнгөрсөнд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчилт их байх тусам суралцах эрч хүч багасдаг байна. Харин ирээдүйд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчилтнь хичээлдээ уусч орох чадвартай (.077*, p<0.042) шууд сул хамааралтай байна. Өөрөөр хэлбэл ирээдүйд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчилт их байх нь хичээлдээ уусч орох чадварыг нэмэгдүүлдэг байна. Өнгөрсөнд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчилт нь ирээдүйд чиглэсэн үл тэвчилттэй (.775**, p<0.001) шууд хүчтэй хамааралтай байна.Мөн Суралцах эрч хүч нь хичээлдээ өөрийгөө зориулах чадвартай (.747**, p<0.001) шууд хүчтэй хамааралтай байгаа бол хичээлдээ өөрийгөө зориулах чадвар нь хичээлдээ уусч орох чадвартай (.692**, p<0.001) дунд зэргийн хамааралтай байлаа (Хүснэгт 4).

Хэлцэмж: Бидний судалгаанд оролцсон оюутнуудын хувьд тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих чадвар сул буюу тодорхойгүй нөхцөл байдлыг үл хүлцдэг болох нь үр дүнгээр батдагдлаа. Тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих нь санаа зовнилийг ихээр нэмэгдүүлдэг[15]. Судалгааны үр дүнгээс харвал ирээдүйд чиглэсэн түгшилт их байх тусам хичээлдээ уусч орох чадварыг нэмэгдүүлдэг байна.

Ирээдүйд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих гэдэг нь ирээдүйд болох үйл явдлыг тодорхой байлгах гэж хичээх урьдчилан таамаглах хүсэл эрмэлзэлтэй байдлыг хэлдэг. Энэхүү урьдчилан таамаглах хүсэл тодорхой байлгах гэсэн хичээлт нь улмаар санаа зовнилыг ихээхэн ихэсгэдэг байна[16]. Тиймээс оюутнууд урьдчилан таамаглах хүсэл эрмэлзэлтэй байх тусам тэд хичээлдээ илүү мэрийлттэй байж суралцахдаа уусан нэгдэх чадвартай байдаг байна.

Харин эсрэгээр өнгөрсөнд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих нь суралцах эрч хүчийг багасдаг байна. Учир нь өнгөрсөнд чиглэсэн тодорхойгүй нөхцөл байдлыг үл тэвчих нь санаа зовнилын хэв шинжийг хадгалахад тусалдаг зайлсхийх зан төрхийг улам өдөөдөг юм[17,16]. Тиймээс өнгөрсөнд чиглэсэн үл тэвчих хандлага өндөртэй оюутнууд өдөр тутмын амьдралынхаа бүх талбарт, тэр дундаа хичээлдээ идэвхитэй оролцохоос зайлсхийх зан төрхтэй байдаг байж болох юм.

Энэхүү судалгаа нь Монгол үндэстэний хувьд анх удаа хийгдэж байгаа давуу талтай боловч богино хугацаанд, зөвхөн анагаахын сургуулийн оюутнуудыг хамруулсан нь зарим үр дүнд сөргөөр нөлөөлсөн байж болно.

Дүгнэлт: Манай улсын оюутан залуусын тодорхойгүй нөхцөл байдлыг тэвчих чадвар сул байсан бөгөөд нийт оюутнуудын дийлэнх хувь нь сурах эрч хүч, сурах үйл явцдаа өөрийгөө зориулах чадвар, хичээлдээ уусан орох зэрэг чадварууд дундаж ба сул түвшинд байгаа нь сурах идэвх оролцоо нь хангалтгүй байгааг харууллаа. **Талархал:** Энэхүү судалгааг хийх нөхцөл бололцоог бүрдүүлж, биднийг тусалж дэмжсэн АШУҮИС, ШУА-ийн харьяа Тархи сэтгэл судлалын хүрээлэн, Этүгэн их сургууль, Монголын Үндэсний Их Сургуулийн хамт олонд талархаж байна.

Ном зүй:

1. *Greco, V. & Roger, D. Coping with uncertainty: The construction and validation of a new measure. Pers. Individ. Dif. 31, 519–534 (2001).*
2. *Buhr, K. & Dugas, M. J. The intolerance of uncertainty scale: psychometric properties of the English version. Behav. Res. Ther. 40, 931–945 (2002).*
3. *Freeston, M. H., Rhéaume, J., Letarte, H., Dugas, M. J. & Ladouceur, R. Why do people worry? Pers. Individ. Dif. 17, 791–802 (1994).*
4. *Dugas, M. J., Buhr, K. & Ladouceur, R. The Role of Intolerance of Uncertainty in Etiology and Maintenance. in Generalized anxiety disorder: Advances in research and practice. 143–163 (The Guilford Press, 2004).*
5. *Buhr, K. & Dugas, M. J. The role of fear of anxiety and intolerance of uncertainty in worry: anexperimental manipulation. Behav. Res. Ther. 47, 215–223 (2009).*
6. *Boswell, J. F., Thompson-Hollands, J., Farchione, T. J. & Barlow, D. H. Intolerance of uncertainty: a common factor in the treatment of emotional disorders. J. Clin. Psychol. 69, 630–645 (2013).*
7. *Holaway, R. M., Rodebaugh, T. L. & Heimberg, R. G. The Epidemiology of Worry and Generalized Anxiety Disorder. in Worry and its psychological disorders:Theory, assessment and treatment. 3–20 (Wiley Publishing, 2006). doi:10.1002/9780470713143.ch1.*
8. *Tolin, D. F., Abramowitz, J. S., Brigidi, B. D. & Foa, E. B. Intolerance of uncertainty in obsessive-compulsive disorder. Journal of Anxiety Disorders vol. 17 233–242 (2003).*
9. *Dugas, M. J., Freeston, M. H. & Ladouceur, R. Intolerance of uncertainty and problem orientation in worry. Cognit. Ther. Res. 21, 593–606 (1997).*
10. *Lind, C. & Boschen, M. J. Intolerance of uncertainty mediates the relationship between responsibilitybeliefs and compulsive checking. J. Anxiety Disord. 23, 1047–1052 (2009).*
11. *Satici, B., Saricali, M., Satici, S. A. & Griffiths, M. D. Intolerance of Uncertainty and Mental Wellbeing: Serial Mediation by Rumination andFear of COVID-19. Int. J. Ment. Health Addict. 1–12 (2020) doi:10.1007/s11469-020-00305-0.*
12. *Steketee, G., Frost, R. O. & Cohen, I. Beliefs in obsessive-compulsive disorder. J. Anxiety Disord. 12, 525–537 (1998).*
13. *Schaufeli, W. B. & Bakker, A. B. Utrecht work engagement scale Preliminary Manual Version 1.1. Occup. Heal. Psychol. Unit Utr. Univ. 1–60 (2004) doi:10.1037/t01350-000.*
14. *Carleton, R. N., Norton, P. & Asmundson, G. Fearing the unknown: A short version of the Intolerance of Uncertainty Scale. J. Anxiety Disord. 21, 105–117 (2007).*
15. *Gu, Y., Gu, S., Lei, Y. & Li, H. From Uncertainty to Anxiety: How Uncertainty Fuels Anxiety in a Process Mediated byIntolerance of Uncertainty. Neural Plast. 2020, 8866386 (2020).*
16. *Berenbaum, H., Bredemeier, K. & Thompson, R. J. Intolerance of uncertainty: Exploring its dimensionality and associations with needfor cognitive closure, psychopathology, and personality. J. Anxiety Disord. 22, 117–125 (2008).*
17. *Yao, N., Qian, M., Jiang, Y. & Elhai, J. D. The Influence of Intolerance of Uncertainty on Anxiety and Depression Symptoms in Chinese-speaking Samples: Structure and Validity of The Chinese Translation of The Intolerance of Uncertainty Scale. J. Pers. Assess. 103, 406–415 (2021).*

The comparison study of Intolerance of Uncertainty and Study engagement among university students

Enkhzaya B[1], Enkhsaikhan T[2], Delgermaa Ts[3], Doldorsuren D[3], Enkhnaran T[4], Tserendolgor U[5], Xihua Zeng[1], Gantstetseg T[4,6]

[1]Department of Psychology, School of Public Health, SMU, Guangzhou, China
[2]National Center of Mental Health
[3]Dornogovi Medical School, MNUMS
[4]Brain and Mind Institute, Mongolian Academy of Scinces
[5]Etugen University
[6]Department of Mental Health, MNUMS
E-mail: enkhzaya.ba@gmail.com , Tel: +976-88008835

Background: The strict quarantine of pandemic has a negative impact on students' learning and social interaction such as increasing uncertainties and decreasing study engagement.
Aim: To assess students' intolerance of uncertainty and study engagement, and explore its' associations.
Target of the study: To determine the level of intolerance of uncertainty and the level of study engagement among study participants by using internationally used questionnaires.
Material and Method: The study was designed as a cross-sectional study with a self-report questionnaire and conducted between December 5th and February 5th of 2022. The Utrecht Work Engagement Scale for students (UWES-S) and Intolerance of Uncertainty Scale (IUS-12) are used in the current study. Statistical analysis was performed using SPSS version 24.
Results: A total of 697 students aged 17-29 were included in this study, with an average age of 21.03±1.85. The total mean score of the IUS-12 questionnaire was 38.65±8.48, and when considering the sub-dimension, the students were more likely to be intolerant toward prospective IU (22.78±4.96) than inhibitory IU (15.87±4.03). While the students' study engagement was reported from weak to an average level of vigor (average 47.1%, weak 34.3%), dedication (average 62.7%, weak 26.3%), and absorption (average 58.5%, weak 23.8%) upon their studies.
Conclusion: The student who participated in the current study showed a higher level of intolerance of uncertain situations and a lower level of study engagement.

Keywords: COVID-19, student, cross-sectional study, IUS-12, UWES-17